

“Шуудангийн илгээмж хүргэх хугацааг
тогтоох тухай”

Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6¹ дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1.Улс хоорондын болон дотоодын шуудангийн илгээмж хүргэх хугацааг
дараах байдлаар тогтоосугай. Үүнд:

1.1.Ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 2 хоног, аймаг,
хотын хооронд 5 хоног, бусад газар /улс хооронд, сум, баг гэх мэт/-т 9
хоногийн дотор;

1.2.Буухиа зэрэглэлийн илгээмжийг хүргэх хугацааг үйлчлэгч
хоорондын гэрээнд зааснаар тодорхойлох бөгөөд энэхүү тогтоолын 1.1 дэх
хэсэгт заасан хугацаанаас бага байхаар тогтоосугай.

2. Энэхүү тогтоолыг мөрдөж ажиллахыг холбогдох тусгай зөвшөөрөл
эзэмшигчдэд үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга
/Г.Чинзориг/-д даалгасугай.

**“Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох тухай”
ХХЗХ-ны тогтоолд нэмэлт өөрчлөлт танилцуулга**

Шуудангийн тухай хуульд 2019 оны 05-р сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсанаар хуулийн 9.1.6-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо нь шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр болсон.

Дэлхийн шуудан холбооны байгууллага болон бусад глобаль сүлжээ (DHL, FedEx, UPS г.м)-ний шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох аргачлалд нийцүүлэн өөр өөр хөгжлийн түвшний үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд нийцэх боломжтой байх зарчимд үндэслэн мөн шуудангийн илгээмж хүргэх хугацааг мөрдүүлэх, хяналт тавих шалгуур үзүүлэлтийг тоон хэмжигдэхүүнээр илэрхийлэн үнэлэх аргачлалыг ХХЗХ-ны даргын 2019 оны А/295 тоот тушаалаар баталсан.

Дээрх аргачлалаар Шуудангийн тухай хуулийн 19.2 дахь заалтын дагуу шуудангийн илгээмжийг хүргэх хугацааг ердийн, буухиа гэсэн зэрэглэлээс хамааруулан шуудангийн илгээмж хүргэх хугацааг дотоодын болон улс хоорондын гэсэн ангилалтайгаар тогтоож тус хорооны 2023 оны 57 дугаар тогтоолоор баталсан.

Шуудангийн илгээмжийг хүргэх хугацаанд шуудангийн илгээмжийг хэрэглэгчээс хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэн дамжуулах, хаягт эзэнд нь хүргэх хүртэлх хугацаа хамаарна.

Шуудангийн илгээмж хүргэх хяналтын хугацааг тогтоох хяналтын ажлыг 2020 оноос хойш хийж гүйцэтгэсэн. Хяналтын ажлаар Дотоодын шуудангийн илгээмж хүргэх хугацаа 9 хоног, Улс хоорондын шуудангийн илгээмж хүргэх хугацаа 9 хоног гэсэн үр дүн гарсан тул шуудангийн илгээмж хүргэх хугацааг дараах байдлаар өөрчлөлт оруулахаар тогтоолын төслийг боловсруулав. Үүнд:

1.1.Ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 2 хоног, аймаг, хотын хооронд 5 хоног, бусад газар /улс хооронд, сум, баг гэх мэт/-т 9 хоногийн дотор;

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО